

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2019 оны 11 дүгээр сарын 04

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	<p>“Мон-Энержи Консалт” ХХК–тай хамтран инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлыг эрчимжүүлэх, цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн асуудлыг шийдвэрлүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын Гишүүн С.Батболд, Ц.Цогзолмаа, Ц.Мөнх-Оргил, Д.Цогтбаатар болон Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлого хариуцсан нэгдүгээр орлогч дарга Ж.Батбаясгалан, Дүүргийн Засаг дарга Ц.Сандаг-Очир нарт Паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаан хангамжийн тооцоолол болон 2020 онд эхлүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлуудыг тус тус танилцуулж, дэмжлэг хүсэх зорилгоор албан бичиг хүргүүлэв. - Паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах асуудлыг шийдвэрлүүлэхээр ЭХЯ-ны сайд Ц.Даваасүрэнд 10 дугаар 21-ний өдрийн 174 дугаар албан бичгээр хүсэлт уламжлан, тус яамны зөвлөх Болдбаатартай уулзалт зохион байгуулсны үр дүнд уг асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахаа яамнаас мэдэгдэв. - Паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаан хангамжийн асуудлаар “Мон Энержи Консалт” ХХК нь “Диспетчерийн үндэсний төв ХХК”-д албан бичгээр хандан цахилгааны горим ачааллын тооцоо хийх үнийн саналыг авч БХБЯ-нд танилцуулсан. - “Мон-Энержи Консалт” ХХК нь зураг төсөлд магадлал хийх дүрмийн дагуу “Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар”-аар Паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийг хянуулахаар албан бичиг хүргүүлсэн боловч тус байгууллагаас инженерийн шугам сүлжээнд хяналт хийх боломжгүй хариуг өгсөн. 	100%

		<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газраас Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн батлагдсан Ерөнхий төлөвлөгөөг дахин нягталж тодотгол хийсэн. Уг тодотголын дагуу "Мон Энержи Консалт" ХХК нь зураг төсөлд нэмэлт өөрчлөлтийг тусгаж магадлалаар оруулахаар бэлтгэж байна. - Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцсэн дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд паркийн дэд бүтцийн цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалтын асуудлыг тусгуулах саналыг тавьж, хуралдаанд оролцов. 	100%
2	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	<p>Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн "Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилгын зураг төслийг хийлгэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 1067 м.кв газрын гэрчилгээг гаргуулж Хөрөнгө оруулалтын газарт хуулбарыг хүргүүлсэн. - Паркийн "Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилгын зураг төслийн хураангуй тендерийг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019.10.04-2019.10.14-ний хооронд зарлаж, 2019.10.28-нд санхүүгийн саналыг нээж гүйцэтгэгч байгууллагаар "Нутаг консалтинг" ХХК шалгарсан бөгөөд хуулийн дагуу мэдэгдлийн хугацаа 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр дуусна. 	100%
3	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ"-г гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан "Санни трэйд" ХХК-тай 2019.10.10-нд уулзалт хийж, паркийн зохион байгуулалт болон эзэмшил 414 га газрыг үзүүлж, шаардлагатай баримт бичгүүдийг өгч хамтран ажиллаж байна.	100%
4	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаал	<p>Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоол болон ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалын 1, 3 дугаар хавсралтын дагуу байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2019.10.23-нд дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс зохион байгуулсан Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, тайлагнах арга зүйн сургалтад нийт албан хаагч нарыг хамруулсан. БҮТП нь орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар учраас зохион байгуулалтын нэгж болон албан хаагч нар гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй бөгөөд 2019.11.10-нд дүүрэгт Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хүргүүлэхээр болсон.</p>	100%

5	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны А/518 дугаар захирамж	2019.10.04-ний өдөр Улсын үзлэгийн нийслэлийн салбар комисст Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт болон архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологийг нэвтрүүлсэн байдал гэсэн 4 үндсэн чиглэлээр биелэлтийг гаргаж Илтгэх хуудсаар Нийслэлийн архивын газарт тайлагнасан.	100%
6	Багануур дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/147 дугаар захирамж	Байгууллагын үйл ажиллагааг шалган зааварласан дүүргийн ажлын хэсгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний явцын тайланг дүүргийн ТЗУХ-т хүргүүлсэн.	100%
7	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6.5	"Багануур тохижилт" ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу хог хаягдлаар бордоо хийх сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах ажлын хүрээнд: <ul style="list-style-type: none"> - 2019 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 1 дүгээр хороо, хуцаа 11-6 тоотын Ө.Чимэддорж, 4 дүгээр хороо, Тогос-уул, Ц. Мөнхжаргал нарын компост бордоо бие даан хийсэн туршилтыг шалгаж зөвлөгөө өгөв. - Тус байгууллагын албан хаагч нараас 10 дугаар сард хог хаягдлаар бие даан бордоо хийсэн 2 албан хаагч /Т.Наранцэцэг, Ц.Мөнхжаргал/ байна. 	100%
8	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.4	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналуудын дэмжүүлэхээр Монгол Улсын Их Хурлын Гишүүн С.Батболд, Ц.Цогзолмаа, Ц.Мөнх-Оргил, Д.Цогтбаатар болон Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлого хариуцсан нэгдүгээр орлогч дарга Ж.Батбаясгалан, Дүүргийн Засаг дарга Ц.Сандаг-Очир нарт 2020 онд эхлүүлэх паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлуудыг танилцуулж, дэмжлэг хүссэн албан бичгүүдийг хүргүүлсэн.	100%
9	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2	Бүгд Найрамдах Буриад Улсын Аж үйлдвэрийн паркттай холбоо тогтоож, 10 дугаар сарын 7-ны өдөр туршлага судлах албан хаагчдын мэдээллийг promparkrb@mail.ru цахим хаягаар хүргэсэн боловч паркийн даргын ажлаас хамаарч уг ажил түр хойшлогдов.	100%
10	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.7	Шинэ Анагаах Ухааны Их Сургуультай хамтын ажиллагааны хүрээнд үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн эрдэст, компост бордоог шинжлэх багш нарын баг гаргаж ажиллаж эхэлсэн.	100%
Нэмэлт ажлууд			

11	БҮТП-ийн газарт Шинжлэх ухааны парк байгуулах боломжийг судлах зорилгоор Азийн хөгжлийн банкны газрын асуудал хариуцсан зөвлөх Пүрэвсүрэн, Табанакат нарыг 2019 оны 10 дугаар сарын 19-ны өдөр хүлээн авч, газар өмчлөлийн бичиг баримтууд, талбайн байршлын зураглалыг танилцуулж, паркийн бүсүүдийн газрыг үзүүлсэн. Мөн 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Азийн хөгжлийн банкны Олон улсын байгаль орчны зөвлөх, эксперт Жон Картер болон Гансүх нарыг хүлээн авч, паркаа танилцуулан, байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг цахимаар өгч, паркийн эзэмшил газруудыг танилцуулсан.	100%
12	2019.10.21-нд Хөнгөн аж үйлдвэрийн салбарын 85 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан улсын зөвлөгөөнд Хуулийн зөвлөх, Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн болон Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер нар оролцов.	100%
13	2019.10.31-ний өдөр Газрын тосны хэрэг эрхлэх газрын хурлын танхимд болсон “Хүнд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг”-т паркийн УТА-ны ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл оролцов.	100%
14	“Ирээдүйд хэрэгжих томоохон төслүүдийн эрчим хүчний хэрэглээ”-ний судалгааг БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөөний томсгосон тооцоонд үндэслэн боловсруулж НШУҮИГ-т хүргүүлэв.	100%
15	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/897 дугаар захирамжийн дагуу байгууллагын гадна хаягийг баталсан загварын дагуу шинэчлэх ажлыг зохион байгуулан хэвлэлийн газарт захиалга өгч, дүүргийн ЗАА-нд тайланг цахимаар хүргүүлсэн.	100%
16	Нийслэлийн Засаг даргын 2019.10.09-ний өдрийн А/1054 дүгээр захирамжаар “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журам”-ыг хавсралтаар баталсан. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмыг дэлгэрэнгүй судалж, танилцахыг албан хаагч нарт үүрэг болгож, хамт олны хурлаар хэлэлцэн ажил үүргийн хуваарилалт хийж хэрэгжилтийг хангуулж байна.	100%
17	Байгууллагын санхүүгийн 3 дугаар улирлын санхүүгийн тайланг гаргаж нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, “Шилэн данс” цахим хуудсанд мэдээллийг байршуулж, хуулийн хэрэгжилтийг мөрдөн ажиллаж байна.	100%
18	УИХ-ын 2018 оны 61 дүгээр тогтоолоор Багануур дүүрэгт Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилготой конторын барилгыг газрын хамт нийслэлийн өмчид шилжүүлсэн боловч өдийг хүртэл нийслэлийн өмчид бүртгээгүй, НИТХ-аар хэлэлцүүлээгүй байна. Иймд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл хариуцан мэргэжилтэн Б.Адьяад УУХҮЯ-аас балансад тусгагдсан үнийн дүнг авч, паркаас шаардлагатай зураг, гэрчилгээ, барилгын талбайн мэдээлэл зэргийг өгч, хамтран ажиллаж байна.	100%
19	Багануур дүүрэг 2019 оны “Иргэдийн амьдрах орчныг сайжруулах жил” болгон зарласан бөгөөд дүүрэг байгуулагдсаны 40 жилийн ойг угтах ажлын хүрээнд Паркийн зүгээс үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст, компост бордоо хийх танхимын сургалт зохион байгуулах тухай 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 152-159,	100%

	<p>161, 167-171, 173-176, 178, 180 дугаар албан бичгийг дүүргийн нийт 20 байгууллагад хүргүүлэн 10 дугаар сард явуулах сургалтын хуваарийг гаргав.</p> <ul style="list-style-type: none"> - 10 дугаар сарын хуваарийн дагуу 2019.10.25-нд V хороо, 2019.10.30-нд IV хорооны албан хаагч, иргэдэд танхимын сургалтыг паркийн инженер мэргэжилтнүүд зохион байгуулав. - Дүүргийн ЗДТГ-тай хамтран баталсан 2018 оны төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст компост бордоо хийх сургалтыг дүүргийн хороодод явуулсан тухай тайланг гаргаж цаашид авах арга хэмжээний талаарх саналыг боловсруулж байна. - 2019.10.10-ны өдөр ЖДҮДТ-ийн дарга Баянмөнхтэй хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх модон тоглоомын загвар гаргах судалгаа хийх, ЖДҮ болон өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст, компост бордоо хийх сургалт зохион байгуулах тухай асуудлыг хэлэлцэж уулзалт хийв. - 2019.10.11-ний өдөр ЗДТГ-ын дарга П. Баттүшиг, ЗАА-ны мэргэжилтэн Золзаяа нартай ҮТА-ны ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл хүүхдийн модон тоглоомын загвар гаргах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст, компост бордоо хийх сургалт зохион байгуулах, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тухай асуудлаар уулзалт зохион байгуулав. Мөн тус өдөр ЗАА-ны Агаарын бохирдол, байгаль орчны мэргэжилтэн М. Долгорын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаар мэдээлэл авав. - 2019.10.14-ний өдөр ЗАА-ны дарга Дэмчигжавтай ҮТА-ны ахлах мэргэжилтэн Д.Алтангэрэл хүүхдийн модон тоглоомын загвар гаргах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст, компост бордоо хийх сургалт зохион байгуулах, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тухай асуудлаар уулзалт зохион байгуулав. 	
20	2019.10.07-ны өдөр “Багануур” ХК-ийн Судалгаа хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Найданзул, Амарсайхан нартай паркийн ҮТА-ны ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл уулзалт хийж нүүрсний шихтовка хийх боломжийн талаар мэдээлэл солилцов.	100%
21	2019.10.08-ны өдөр паркийн Үйлдвэрлэл, технологийн албаны инженерүүд “Багануур-Ус” ОНӨААТҮГ-ын дарга Буддорж, инженер Мөнхцэцэг нартай Багануурын цэвэрлэх байгууламжийн лаг боловсруулах судалгааны талаар уулзалт хийв.	100%
22	2019.10.10-ны өдөр ҮТА-ны ахлах мэргэжилтэн Д.Алтангэрэл Төв аймгийн Баянцагаан нүүрсний ордын нүүрсний талаарх мэдээллийг авав.	100%
23	2019.10.22-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханы Багануур дүүргийн иргэдтэй хийх уулзалтад паркийн нийт албан хаагч хамрагдан, Нийслэл болон дүүрэгт хийгдэж байгаа томоохон хөрөнгө оруулалтын ажлуудын явц болон баримталж буй бодлого шийдвэрийн талаар мэдээлэл авав.	100%
24	“Хүн ам орон сууцны ээлжит тооллого – 2020” явагдаж байгаатай холбогдуулан “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-д нэвтэрч мэдээллээ баталгаажуулсан албан хаагчдын мэдээг нэгтгэн нийслэлийн Статистикийн газарт хүргүүлсэн.	100%
25	2019.10.25-нд намрын бүх нийтийн их цэвэрлэгээний зохион байгуулалтад оролцож, албан хаагчдыг бүрэн хамруулан дүүргийн Хүүхэд залуучуудын паркийн хашааны эргэн тойрны унасан навч, хатсан зэрлэг, хог хаягдлыг	100%